

ГОВЬСҮМЭР АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН ГАЗАР

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙДАЛ**

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2016/3





www.1212.mn



**СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН САН**



www.nso.mn сайтын
Хэрэглэгийн бүртгэлд
бүртгүүлснээр
цахим хаягаар
тогтмол авч болно.



Monstat ezStat
аппликейшн



1900-1212



Лавлах утас

**Үндэсний
Статистикийн
хорооны
НОМЫН САН**

@statistic_mn



Статистик
мэдээлэл



Онлайн лавлах
мессенжер
8:30-17:30

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

ХҮНД СУРТАЛ
АВЛИГА

ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ
ХҮРГЭНЭ



ГАРЧИГ

- Ерөнхий тэмдэглэл
- Аргачлалын тайлбар.....
- I.Нийгмийн байдал.....
- II. Нийгмийн даатгал, халамж.....
- III.Эрүүл мэнд
- IV.Гэмт хэрэг
- V.Үнэ.....
- VI.Төсөв.....
- VII.Хөдөө аж ахуй
- VIII. Аж үйлдвэр
- IXI.Тээвэр.....
- XI. Холбоо.....
- XII.Цаг агаарын мэдээ.....
- Хавсралт.....



Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон тэмдэглэл:

Сумдын нэр:

СҮ Сүмбэр

БТ Баянтал

ШГ Шивээговь

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

Тухай сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XII зэргээр илэрхийлэв.

III. Дараахь тэмдэглэлийг ашиглав:

... Мэдээлэл байхгүй

0.0 Маш бага тоо+, - Зөрүү

- Гүйцэтгэл байхгүй* Дахин

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

• Хөдөлмөр:

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

• Нийгмийн даатгал, халамж:

✓ Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.



✓ Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчийн нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

- **Эрүүл мэнд**

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөнд тооцно.

✓ **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.**

✓ **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.**

- **Гэмт хэрэг:**

Эрүүгийн хуульд эрүүгийг нхариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэрхэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

✓ Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг гнэгтгэн оруулсан.

✓ Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.

✓ Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.



✓ Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.

✓ Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.

- **Үнэ**

Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / нь хэрэглэгчийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

- **Төсөв санхүү:**

Аймгийн төсвийн мэдээг СанхүүТөрийн сангийн Хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.

- **Хөдөө аж ахуй:**

Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.

✓ Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

✓ Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул зэрэг хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

- **Аж үйлдвэр:**

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

(2016 оны 3 дугаар сарын байдлаар)



I. Нийгмийн байдал

I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн


Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2016 оны 3 дугаар сард 286 байгаагийн 160 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 84 буюу 41.5 хувиар, өмнөх сарынхаас 42 ажил хайгч буюу 17.2 хувиар тус тус өссөн байна.

Эхний 3 сарын байдлаар Хөдөлмөрийн хэлтэст 66 ажлын байрны захиалга ирсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 27 буюу 69.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хөдөлмөрийн хэлтсээр эхний 3 сард 25 иргэн ажилд зуучлуулсны 17 нь буюу 68.0 хувь эмэгтэйчүүд байлаа.

Зураг.I.1

Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэн, үүнээс эмэгтэй,
жил бүрийн эхний 3 дугаар сарын байдлаар



Ажил хайгч иргэдийн 54.2 хувийг бүрэн дунд, 16.4 хувийг дипломын болон бакалаврын, 10.1 хувийг техникийн болон мэргэжлийн, 7.7 хувийг тусгай мэргэжлийн дунд, 3.6 хувийг бага боловсролтой, 5.9 хувийг суурь, 2.1 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.



I.2 Ердийн хөдөлгөөн


Улсын бүртгэл, статистикийн газрын Бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 3 дугаар сарын байдлаар 102 эх амаржиж, 103 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх болон мэндэлсэн хүүхэд 1 буюу 1.0 хувиар өссөн байна.

Мөн нас баралт 27, бүртгүүлсэн гэр бүл 14, цуцалсан гэр бүл 3, үрчлэгдсэн хүүхэд 3 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс нас баралт 4 буюу 17.4 хувиар өсч, бүртгүүлсэн гэр бүл 2 буюу 12.5 хувиар, цуцалсан гэр бүл 2 буюу 40.0 хувиар тус тус буурсан бол үрчлэгдсэн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеийнхтэй ижил түвшинд байна.

Тайлант хугацаанд 223 иргэн нийслэл болон бусад аймгуудаас шилжин ирж, 163 иргэн нийслэл болон бусад аймаг руу шилжин явсан байна. Өмнөх оны мөн үеийнхээс шилжин ирсэн иргэн 81 буюу 57.0 хувиар, шилжин явсан иргэн 53 буюу 48.2 хувиар тус тус өссөн байна.

Зураг.I.3

Шинэ төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 3 сарын байдлаар



II. Нийгмийн даатгал, халамж

II.1 Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 3 дугаар сард 1556.5 сая төгрөг, зарлага 2152.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 81.1 сая төгрөг буюу 4.9 хувиар буурч, зарлага 113.9 сая төгрөг буюу 5.6 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 3 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 81.1 сая төгрөгөөр буурахад тэтгэврийн даатгалын сангийн орлого 53.4 сая төгрөг буюу 5.2 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2016 оны эхний 3 дугаар сард 2152.8 болж, өмнөх оны мөн үеийнхээс 113.9 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 120.4 сая төгрөг буюу 8.2 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.



II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2016 оны эхний 3 сард 3140 хүнд 416.7 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамж авагчдын тоо 422 хүн буюу 15.5 хувиар, олгосон нийгмийн халамжийн сан 34.4 сая төгрөг буюу 9.0 хувиар тус тус өссөн байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2016 оны эхний 3 сард 1001 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 58 хүн буюу 5.5 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 2.9 сая төгрөг буюу 1.5 хувиар тус тус буурсан байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжинд 2016 оны эхний 3 сард 2139 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 480 хүн буюу 28.9 хувиар буурч, олгосон халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламж 37.3 сая төгрөг буюу 20.0 хувиар өссөн үзүүлттэй байна.


II.3 Дундаж цалин

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн эхний 3 сарын мэдээгээр 178 байгууллагын 4477 даатгуулагч иргэн, үүнээс 469 нь сайн дурын даатгуулагч байна. Нийт даатгуудагчдын цалин өссөн дүнгээр 9.5 тэрбум төгрөг байгаа бол сарын дундаж цалин сайн дурын даатгуулагч ороогүй дүнгээр 771.8 мянган төгрөг байна.

Ажиллагсдын цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 21 аж ахуй нэгжийн 1098 даатгуулагчийн дундаж цалин нь 963.2 мянган төгрөг, төсөвт 53 байгууллагын 1481 ажилтны цалин дундаж цалин нь 691.1 мянган төгрөг, 7 ХКомпанийн 608 ажилтны дундаж цалин нь 1083.8 мянган төгрөг, 76 ХХКомпанийн 684 ажилтны цалин дундаж цалин нь 419.7 мянган төгрөг, бусад 21 байгууллагын 137 ажилтны дундаж цалин нь 484.2 мянган төгрөг боллоо.



Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2016 оны эхний 3 дугаар сарын байдлаар




III. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2016 оны эхний 3 сарын байдлаар 105 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 103 үүнээс 54 нь хүү, 49 нь охин байна. Өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 7 буюу 7.1 хувиар, төрсөн хүүхэд 6 буюу 6.2 хувиар тус тус өссөн байна.

Зураг III.1 Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 3 сарын байдлаар




0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 ба 1000 амьд төрөлтөд 38.8 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.9 промилоор нэмэгдсэн, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл бүртгэгдээгүй байна.



Эхийн эндэгдэл, гэрийн төрөлт, бүртгэгдээгүй болно. Халдварт өвчин эхний 3 сарын байдлаар 98 буюу 10000 хүн амд 62.7 байгаа нь өмнөх оны мөн үеэс 82 тохиолдлоор нэмэгдэж, нийт өвчлөлд улаанбурхан өвчин 73.4 хувийг эзэлж байна.

Зураг III.2

Нас баралт, жил бүрийн эхний 3 сарын байдлаар




Он гарсаар 33909 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 7691 буюу 29.3 хувиар, 1324 хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 233 буюу 21.3 хувиар тус тус өссөн байна.

2016 оны эхний 3 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 2101 удаа гарч, осол гэмтлийн өвчлөл 193, халдварт өвчин 98 бүртгэгдсэн байна.

Зураг III.3

Осол гэмтлийн болон халдварт өвчний өвчлөл,
жил бүрийн эхний 3 сарын байдлаар






IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 3 сард 47 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 4 хэрэг буюу 7.8 хувиар буурсан байна.

Зураг IV.1

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо,
жил бүрийн эхний 3 сарын байдлаар




Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо буурахад хүний амь, бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 4 буюу 16.0 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэргийн тоо 10 , гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 66.0 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс илрээгүй гэмт хэрэг 1 буюу 9.1 хувиар буурч, илрүүлэлтийн хувь 7.9 пунктээр өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 28 хүн гэмтэж, 1 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо ижил түвшинд, нас баралт 1 буюу 50 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг IV.2

Гэмт хэргийн ангилал,
жил бүрийн эхний 3 сарын байдлаар





Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2016 оны 3 сарын байдлаар 72.0 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 32.0 сая төг болж, өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирлын хэмжээ 542.0 сая төгрөг буюу 88.2 хувь, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 32.0 сая төгрөг буюу 80.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2016 оны эхний 3 сард 217 хүн эрүүлжүүлэгдэж, 6 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 5 буюу 2.3 хувь, баривчлагдсан хүний тоо 33 буюу 84.6 хувь буурсан байна.

Зураг IV.3

Албадан болон сайн дурын эмчилгээнд хамруулсан, эрх хасуулсан хүний тоо, жил бүрийн эхний 3 сарын байдлаар



Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2016 оны 3 сард 105.2 болж өмнөх оны мөн үеийнхээс 5.2 хувиар өсч, жилийн эцсээс 0.1 хувиар буурсан, өмнөх сараас 0.2 хувь өссөн үзүүлэлттэй байна.




Хэрэглээний үнийн индекс, 2016 оны 3 дугаар сард, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	2016. III	2016. III	2016. III
	2015. III	2015. XII	2016. II
Ерөнхий индекс	105.2	99.9	100.2
Хүнсний бараа, ундаа, ус	98.1	100.1	100.8
Согтууруулах ундаа, тамхи	97.7	100.3	99.9
Хувцас, бөс бараа, гутал	113.9	100.0	100.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	101.9	97.9	97.9
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	103.8	100.2	100.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	103.3	100.0	100.0
Тээвэр	98.3	97.6	99.9
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.3	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	102.9	102.6	102.6
Боловсролын үйлчилгээ	132.5	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	127.3	111.9	111.6
Бусад бараа, үйлчилгээ	104.3	100.9	100.2

Ерөнхий индекс өмнөх оны мөн үеийнхээс 5.2 хувиар өсөхөд боловсролын үйлчилгээ 32.5 хувиар, өмнөх сарынхаас 0.2 хувиар өсөхөд зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны бүлгийн үнэ 11.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс, 2016 оны 3 дугаар сар, (өмнөх сар=100%)





VI. Орон нутгийн төсөв


2016 оны эхний 3 сарын байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 3690.2 сая төгрөг, гүйцэтгэлээр 3393.2 сая төгрөг болж нь өмнөх оны мөн үеийнхээс төсвийн орлогын гүйцэтгэл 327.1 сая төгрөг буюу 10.7 хувиар өсчээ.

Аймгийн төсвийн нийт зарлага 3916.3 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 3039.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 877.0 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Төсвийн нийт зарлага өмнөх оны мөн үеийнхээс 308.4 сая төгрөг буюу 11.3 хувиар өссөн байна.

2016 оны эхний 3 сарын байдлаар авлагын үлдэгдэл 22.7 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 459.1 сая төгрөг байна. Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал авлагын үлдэгдэл 19.9 сая төгрөг буюу 8.1 дахин, өглөгийн үлдэгдэл 261.9 сая төгрөг буюу 2.3 дахин өссөн байна.

Зураг VI.1

Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн
эхний 3 сарын байдлаар, сая төгрөгөөр






VII. Мал аж ахуй

Аймгийн хэмжээнд 2016 оны эхний 3 дугаар сард төллөсөн хээлтэгч 16014 байна. Эм хонь 7843, эм ямаа 7294, үнээ 730, гүү 122, ингэ 25 төллөжээ. Гарсан төлийн 96.5 хувь буюу 15624 толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 21200 толгойгоор бага байна.

2016 оны эхний 3 сард том малын зүй бус хорогдол 8111 болж, өмнөх оны мөн үеийнхээс 8015 толгойгоор өссөн байна. Нийт хорогдолд өвчнөөр хорогдсон 2 мал байна.


Зураг VII.1

Төл бойжилт, жил бүрийн эхний 3 сараар, толгойгоор



Зураг VII.2

Хорогдсон хээлтэгч, жил бүрийн эхний 3 сараар, толгойгоор






VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2016 оны эхний 3 сард 12966.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 4144.5 сая төгрөг буюу 47.0 хувиар өссөн ба үүнд уул уурхайн салбарынх 2406.1 сая төг буюу 23.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Оны үнээр 12729.6 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2406.0 сая төгрөг буюу 23.3 хувиар өслөө.

Шивээ-Овоо ХК нь нийт борлуулалтын 11955.6 сая төг буюу 92.2 хувийг дангаараа бүрдүүлсэн байна.

Зураг VIII.1

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар,
жил бүрийн эхний 3 сар, сая төгрөгөөр



IX.ТЭЭВЭР

Авто тээврийн газар 2016 оны эхний 3 сарын мэдээгээр 5.3 мянган зорчигч тээвэрлэж, зорчигч эргэлт 1272.0 мян.хүн км болж , 14 ажилтантай 2.7 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

X. ХОЛБОО


Аймгийн холбооны газрын мэдээгээр 2016 оны эхний 3 сарын байдлаар нийт орлого 49.6 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 8.5 сая төг буюу 14.6 хувиар буурчээ. Нийт орлогод хүн амаас орсон орлого 29.7 сая төг буюу 59.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 5.1 сая төг буюу 17.2 хувиар буурсан байна. Аймгийн хэмжээнд нийт телефон цэгийн тоо 369 болж өмнөх оны мөн үеийнхээс 196 буюу 1 дахин өссөн байна.



2016 оны эхний 3 сарын байдлаар интернэт үйлчилгээний цэгийн тоо 1 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1 дахин багассан үзүүлэлттэй байна. Интернэт үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчийн тоо 16 үүнээс байнгын хэрэглэгчийн тоо 5 байна.

Зураг Х.1

Холбооны нийт орлого, үүнээс хүн амаас орсон орлого,
жил бүрийн эхний 3 сар, сая төгрөгөөр



XI. Цаг агаарын мэдээ

2016 оны 3 дугаар сард 0.8 мм тунадас орж, ихэнх хугацаанд салхи секундэд 3-8 метр байсан ба хамгийн их нь 15 м/с хүрсэн. Агаарын температурын хувьд 3 дугаар сарын 1-р 10 хоногтоо шөнөдөө 13-18 градус хүйтэн өдөртөө 0-5 градус хүйтэн, хоёрдугаар арав хоногтоо шөнөдөө 5-10 градус өдөртөө 1-6 градус дулаан, гуравдугаар арав хоногтоо шөнөдөө 5-10 градус хүйтэн өдөртөө 0-5 градус дулаан байсан. Хамгийн дулаан нь 30-нд 17,0 градус хүйтэн хамгийн бага нь 20-нд 30,6 градус хүйтэн байсан байна.

2016 оны 04-р сарын агаарын температурын урьдчилсан мэдээ

Энэ сарын агаарын дундаж температур Говьсүмбэр аймгийн нутгаар 3-8 градус дулаан ба олон жилийн дунджийн орчим байна. Нэгдүгээр арав хоногийн эхэн болон хоёрдугаар арав хоногийн дунд үеэр хүйтэрч шөнөдөө 5-10 градус хүйтэн өдөртөө 6-11 градус дулаан байна. Гуравдугаар арав хоногийн сүүлчээр хүйтэрнэ. Харин нэг болон гуравдугаар арав хоногийн дунд үеэр харьцангуй дулаарч шөнөдөө 3-8 градус өдөртөө 18-23 градус дулаан байна. Бусад хугацаанд шөнөдөө 3 градус хүйтэнээс 2 градус дулаан өдөртөө 13-18 градус дулаан байна.

2016 оны 04 сарын хур тунадасны урьдчилсан мэдээ

Энэ сард Говьсүмбэр аймгийн нутгаар олон жилийн дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй. Нэг ба гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үеэр бага зэргийн цас



орно. Нэгдүгээр арав хоногийн эхээр цас гуравдугаар арав хоногийн дунд үеэр хур тунадас орох төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн сүүлч хоёр гуравдугаар арав хоногийн дунд үе болон сүүлчээр 18-20 м/с, хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй байна.

ХАА-н үйлдвэрлэлд нөлөөлөх тухай

4 дүгээр сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын температур олон жилийн дунджийн орчим, хур тунадас дунджийн орчим орохоор байна. Цаашид 4-р сард үе үе цасан болон шороон шуурга шуурч малын хариулга маллагаа болон төл хүлээн авахад хүндрэл учруулж болзошгүйг онцгой анхаарна уу.



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 3 сарын байдлаар

	Хэмжих нэгж	2015 III	2016 III	Зөрүү	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}}\%$
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд					
Төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлт)	хүн	97	103	6	106.2
Ажил хайгч иргэдийн тоо, 3 дугаар сарын эцэст	хүн	202	286	84	141.6
Халдварт өвчнөөр өвчлөгчдын тоо	хүн	16	98	82	6.1 дахин
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	51	47	-4	92.2
Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт					
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	3066.1	3393.2	327.1	110.7
Татварын орлого	сая.төг	879.5	1110.7	231.2	126.3
Татварын бус орлого	сая.төг	41.0	92.2	51.2	224.9
Хөрөнгийн орлого	сая.төг	-	-	-	-
Тусламжийн орлого	сая.төг	2185.9	2098.6	-87.3	96.0
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	2730.9	3039.3	308.4	111.2
Бараа үйлчилгээний зардал	сая.төг	2396.1	2624.2	228.1	109.5
Эдийн засгийн үзүүлэлтүүд					
Том малын зүй бусын хорогдол	тол	96	8111	8015	-
- Тэмээ	тол	-	-	-	-
- Адуу	тол	1	267	266	-
- Үхэр	тол	5	347	342	-
- Хонь	тол	41	2954	2913	-
- Ямаа	тол	49	4543	4494	-
Бойжуулсан төл	тол	36824	16014	-20810	43.5
- Тэмээ	тол	60	25	-35	41.6
- Адуу	тол	324	118	-206	36.4
- Үхэр	тол	456	696	240	152.6
- Хонь	тол	17129	7656	-9473	44.7
- Ямаа	тол	18855	7129	-9973	37.8
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая.төг	8821.9	12966.4	4144.5	147.0
Тээврийн орлого	сая.төг	-	2.7	-	-
Холбооны орлого	сая.төг	58.0	49.6	-8.4	14.5



I.1 ШИНЭ АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭ, жил бүрийн эхний 3 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}} \%$
Ажил хайгч иргэнийн тоо	202	286	141.6
Үүнээс эмэгтэй	122	160	131.1
Ажлын байрны захиалга	39	66	169.2
Ажилд жуучлагдсан иргэд	20	25	125.0
Үүнээс эмэгтэй	11	17	154.5

II.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн эхний 3 сарын байдлаар

Сангийн төрөл	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}} \%$
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	1637.7	1556.5	96.2
Тэтгэврийн даатгалын сангийн	1022.3	968.9	94.8
Тэтгэмжийн даатгалын сангийн	115.3	110.7	96.0
Эрүүл мэндийн даатгалын сангийн	153.9	146.3	95.0
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	28.6	26.6	93.0
Ажилгүйдлын даатгалын сангийн	317.5	304.0	95.7
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	2038.8	2152.8	105.6
Тэтгэврийн даатгалын сангийн	1474.7	1595.1	108.2
Тэтгэмжийн даатгалын сангийн	157.8	159.5	101.0
Эрүүл мэндийн даатгалын сангийн	79.7	69.3	87.0
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	34.8	43.0	123.6
Ажилгүйдлын даатгалын сангийн	291.8	285.8	97.9

Тайлбар: *ҮОМШӨ –Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин



II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, 2016 оны 3 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 III		2016 III		$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}} \%$	
	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	2718	382.4	3140	416.7	115.5	109.0
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1059	195.8	1001	192.9	94.5	98.5
Халамжийн тэтгэвэр	278	95.3	248	92.5	89.2	97.0
Нөхцөлт мөнгөн тэтгэмж / Үүнээс: /	781	100.6	753	100.4	96.4	99.8
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж	529	53.0	517	52.8	97.7	99.6
Ахмад настныг асарч буй иргэний асаргааны тэтгэмж	112	17.6	101	16.7	90.2	94.9
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний асаргааны тэтгэмж	118	24.3	119	27.0	100.8	111.1
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөсөн, асарч буй иргэний тэтгэмж	22	5.6	16	3.9	72.7	69.6
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	1659	186.5	2139	223.8	128.9	120.0
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	365	11.3	585	32.6	160.3	265.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	42	3.2	87	10.3	2 дахин	3 дахин
Нийгмийн халамжийн үйлчилгээ	-	-	363	11.5	-	-
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	192	19.7	177	15.6	92.2	79.2
Алдарт цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	10	4.9	7	3.7	70.0	75.5
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1050	147.5	920	150.1	87.6	101.8



III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 3 сарын байдлаар

Үзүүлэлт	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}}\%$
Төрсөн эх	98	105	107.1
Амьд төрсөн хүүхэд	97	103	106.2
Эрэгтэй	44	54	122.7
Эмэгтэй	53	49	92.4
Амьгүй төрөлт	1	2	0.0
Нийт нас баралт	21	19	90.5
Эмнэлгийн нас баралт	5	3	60.0
Хоног болоогүй нас баралт	3	2	66.6
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	3	4	133.3
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	3	4	133.3
Эмчлэгдсэн өвчтөн	1091	1324	121.4
Амбулаторийн үзлэг	26218	33909	129.3
Осол гэмтлийн өвчлөл	186	193	103.8
Халдварт өвчин	16	98	0.0



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ , төрлөөр

Үзүүлэлт	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}}\%$
Бүртгэгдсэн гэмт хэрэг	51	47	-7.8
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг	25	21	-16
Өмчлөх эрхийн эсрэг	21	19	-9.5
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	2	2	0.0
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	0	0	0.0
Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	1	2	1 нэгж
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	0	2	2 нэгж
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	2	1	1 нэгж
Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	0	0	0.0
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	0	0	0.0
Албан тушаалтны эсрэг гэмт хэрэг	0	0	0.0
Иргэдийн улс төрийн болон бусад эрх эрх чөлөөний эсрэг гэмт	0	0	0.0
Гэмт хэрэгт холбогдогсод	40	48	20.0
15 хүртэлх насны	0	1	0.0
16-17 насны	1	3	2 нэгж
18-29 насны	16	27	69.0
30-34 насны	8	9	13.0
35-с дээш	15	8	-47
Боловсрол – Дээд	3	7	133
Боловсрол - Тусгай дунд	4	4	0.0
Боловсрол – Бүрэн дунд	15	23	53.0
Боловсрол – Бүрэн бус дунд	12	6	-50.0
Боловсрол – Бага	4	6	50.0
Боловсролгүй	2	2	0.0
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	2	2	0.0
Ажилгүй иргэд үйлдсэн	17	30	2 дахин
Эмэгтэй хүн оролцсон	2	8	6 дахин
Хүүхэд оролцсон	1	4	3 дахин
Бүлгээр үйлдсэн	2	6	3 дахин
Согтуугаар үйлдсэн	28	17	60.7
Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал	51	47	7.8
Гудамж талбайд	17	13	-23.5
Албан газарт	1	6	5 нэгж
Гэр орон сууцанд	18	20	11.1
Авто зам	1	0	0.0
Бусад газарт	14	8	-42.9
ГХ-н улмаас нас барсан	2	1	50.0
ГХ-н улмаас гэмтсэн	28	28	100.0
Учирсан хохирол / сая.төг /	614.0	72.0	-88.2
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	165.0	32.0	-80.4



V.1 Хэрэглээний үний индекс, 3 дугаар сард, 2016.3, 2015.12, 2016.2 дугаар саруудтай харьцуулснаар

Барааны бүлгээр	2016-3 2015-3	2016-3 2015-12	2016-3 2016-2
Ерөнхий индекс	105.2	99.9	100.2
01. хүнсний бараа, согтууруулах бус ундаа	98.1	100.1	100.8
01.1 хүнсний бараа	97.5	99.6	100.4
01.1.1 талх, гурил, будаа	120.5	98.0	97.8
01.1.2 мах, махан бүтээгдэхүүн	73.7	104.8	106.2
01.1.4 сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг	99.1	97.3	98.5
01.1.5 төрөл бүрийн өөх, тос	91.2	96.2	96.1
01.1.6 жимс, жимсгэнэ	95.9	94.7	99.9
01.1.7 хүнсний ногоо	100.4	107.5	111.0
01.1.8 саахар, жимсний чанамал, зөгийн бал, чихэр, шоколад	87.7	91.6	93.6
01.1.9 хүнсний бусад бүтээгдэхүүн	97.8	98.5	96.3
01.2 согтууруулах бус ундаа	110.1	110.0	109.7
02. согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	97.7	100.3	99.9
02.1 согтууруулах ундаа	100.8	100.7	99.8
02.2 тамхи	96.0	100.0	100.0
03. хувцас, бөс бараа, гутал	113.9	100.0	100.0
03.1 хувцас, бөс бараа	112.9	100.0	100.0
03.1.1 хөвөн, бөс бараа	126.7	100.0	100.0
03.1.2 бүх төрлийн хувцас	112.1	100.0	100.0
03.1.3 жижиг эдлэл, хэрэгсэл	123.0	100.0	100.0
03.2 гутал	116.4	100.0	100.0
04. орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	101.9	97.9	97.9
04.1 орон сууцны бодит түрээс	100.0	100.0	100.0
04.2 орон сууцны техникийн болон засварын үйлчилгээ	101.9	99.6	99.6
04.3 усан хангамж болон орон сууцны бусад үйлчилгээ	100.0	100.0	100.0
04.4 цахилгаан, хийн болон бусад түлш	102.2	96.8	96.8
05. гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	103.8	100.2	100.2
05.1 гэр ахуйн тавилга, хэрэгсэл, хивс болон шалны бусад дэвсгэр	100.7	100.0	100.0
05.2 гэр ахуйн оёмол, нэхмэл эдлэл	99.2	100.0	100.0
05.3 гэр ахуйн цахилгаан бараа	96.8	100.0	100.0
05.4 гэр ахуйн шилэн эдлэл, сав суулга	122.1	100.0	100.0
05.5 гэр ахуй, цэцэрлэгийн зориулалттай хөдөлмөрийн багаж хэрэгсэл	101.1	103.6	103.6
05.6 гэр ахуйн цэвэрлэгээний болон бусад жижиг бараа, гэрийн үйлчилгээ	113.9	100.0	100.0
06. эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	103.3	100.0	100.0
06.1 эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл	105.0	100.0	100.0
06.2 амбулторын үйлчилгээ	100.0	100.0	100.0
06.3 эмнэлэгт хэвтэж үзүүлсэн үйлчилгээ	100.0	100.0	100.0
07. тээвэр	98.3	97.6	99.9
07.1 тээврийн хэрэгслийн худалдан авалт	100.0	100.0	100.0
07.2 хувийн тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ	95.1	95.2	99.8
07.3 тээврийн үйлчилгээ	104.4	100.0	100.0
08. холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.3	100.0	100.0
09. амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	102.9	102.6	102.6
09.1 дуу, дүрс, гэрэл зураг, мэдээллийг боловсруулах тоног төхөөрөмж	100.9	100.0	100.0
09.2 чөлөөт цаг, соёлын үйлчилгээ	115.0	115.0	115.0
09.3 ном, сонин, бичгийн хэрэгсэл	100.2	100.0	100.0
10. боловсролын үйлчилгээ	132.5	100.0	100.0
11. зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	127.3	111.9	111.6
11.1 нийтийн хоолны үйлчилгээ	123.4	100.5	100.0
11.2 зочид буудал дотуур байрны үйлчилгээ	133.3	133.3	133.3
12. бусад бараа, үйлчилгээ	104.3	100.9	100.2
12.1 хувь хунд хандсан үйлчилгээ	105.1	101.0	100.2
12.2 хувь хүний эд зүйл, хэрэглэл	100.0	100.0	100.0
12.3 санхүүгийн үйлчилгээ	100.0	100.0	100.0



VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 3 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}}\%$
Орон нутгийн орлого	3066.1	3393.2	110.7
Татварын орлого	879.5	1110.7	126.3
Орлогын албан татвар	603.4	622.9	103.2
Өмчийн татвар	78.4	10.8	13.8
Дотоодын бараа үйлчилгээний	6.4	-	-
Бусад	150.2	476.9	317.5
Татварын бус орлого	41.0	92.2	224.9
Хөрөнгийн орлого	-	91.7	-
Тусламжийн орлого	2185.9	2098.6	96.0

VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 3 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}}\%$
Бүх зарлага	2730.9	3039.3	111.3
Бараа үйлчилгээний зардал	2396.1	2624.2	109.5
Нийгмийн халамжийн үйлчилгээний зардал	334.8	339.7	101.5
Хөрөнгийн зардал	-	75.3	-
Төсөвт байгууллагын тоо	47	51	108.5
Төсөвт байгууллагын ажиллагсадын тоо	751	769	102.4

VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 3 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}}\%$
Авлага	2.8	22.7	810.7
Өглөг	197.3	459.1	232.7



VII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 3 сарын байдлаар

Төрөл	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}}\%$
Бүгд	36362	16014	44.0
Ингэ	60	25	41.6
Гүү	324	122	37.7
Үнээ	455	730	160.4
Эм хонь	16875	7843	46.5
Эм ямаа	18648	7294	39.1

VII.2 МАЛ ТӨЛЛӨЛТ, сумдаар, жил бүрийн эхний 3 сарын байдлаар

Сумд	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}}\%$
Дүн	36362	16014	44.0
Баянтал	8565	11141	130.0
Сүмбэр	27124	3695	13.6
Шивээговь	673	1178	175.0

VII.3 ТӨЛ БОЙЖИЛТ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 3 сарын байдлаар

Төрөл	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}}\%$
Бүгд	36824	15624	42.4
Ботго	60	25	41.6
Унага	324	118	36.4
Тугал	456	696	152.6
Хурга	17129	7656	44.7
Ишиг	18855	7129	37.8

VII.4 ТӨЛ БОЙЖИЛТ, сумдаар, жил бүрийн эхний 3 сарын байдлаар

Сумд	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}}\%$
Дүн	36824	15624	42.4
Баянтал	8578	11139	129.8
Сүмбэр	27502	3420	12.4
Шивээговь	744	1065	143.1



VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 3 сарын байдлаар

Төрөл	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}} \%$
Бүгд	96	8111	-
Тэмээ	-	-	-
Адуу	1	267	-
Үхэр	5	347	-
Хонь	41	2954	-
Ямаа	49	4543	-

VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 3 сарын байдлаар

Сумд	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}} \%$
Дүн	96	8111	-
Баянтал	3	1346	-
Сүмбэр	81	4119	-
Шивээговь	12	2646	-

VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 3 сарын байдлаар

Төрөл	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}} \%$
Бүгд	40	3076	-
Тэмээ	-	-	-
Адуу	-	209	-
Үхэр	4	140	-
Хонь	19	1117	-
Ямаа	17	1610	-

VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 3 сарын байдлаар

Сумд	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}} \%$
Дүн	40	3076	-
Баянтал	3	131	-
Сүмбэр	30	444	-
Шивээговь	7	2501	-



VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, жил бүрийн эхний 3 сар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}}\%$
Нийт	8821.9	12966.4	147.0
Уул уурхай	10323.6	12729.6	123.3
Нүүрс олборлолт	8118.2	12192.4	150.2
Дулааны эрчим хүч, усан хангамж	703.6	773.9	110.0
Дулаан	655.0	706.3	107.8
Усан хангамж	48.6	67.7	139.0

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн эхний 3 сар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}}\%$
Нийт	8821.9	12966.4	147.0
Уул уурхай	9619.9	11955.6	124.3
Нүүрс олборлолт	8118.2	12192.4	150.2
Дулааны эрчим хүч, усан хангамж	703.6	773.9	110.0
Дулаан	655.0	706.3	107.8
Усан хангамж	48.6	67.6	139.0

VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний нийт үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн эхний 3 сарын байдлаар

Үзүүлэлт	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}}\%$
Бүтээгдэхүүн борлуулалт /Үнийн дүнгээр, сая.төг/	9619.9	11955.6	124.3
Нүүрс борлуулалт /биет хэмжээ, мян.тн/	474.9	510.7	107.5
Нүүрс гаргалт /биет хэмжээ, мян.тн/	404.6	539.7	133.4
Нийт бүтээгдэхүүн /үнийн дүнгээр, сая.төг/	8118.2	12192.4	150.2
Ажиллагсадын тоо	515	595	115.5



IX.1 Авто тээврийн газрын үзүүлэлт, жил бүрийн эхний 3 сарын байдлаар

Үзүүлэлт	Нэгж	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}}\%$
Тээврийн орлого	Мян.төг	1116.8	2722.8	243.8
Зорчигч эргэлт	Мян.хүн км	179.6	1272.0	7 дахин
Зорчигчдын тоо	Мян.хүн	0.6	5.3	8 дахин
Ажиллагсадын тоо	тоо	13	14	107.7

X.1 Аймгийн холбооны газрын үзүүлэлт, жил бүрийн эхний 3 сарын байдлаар

Үзүүлэлт	нэгж	2015 III	2016 III	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}}\%$
Нийт орлого	сая.төг	58.0	49.6	85.5
Үүнээс: Хүн амаас	сая.төг	34.8	29.7	85.3
КаТВ-ийн сувагт холбогдсон хэрэглэгч	тоо	1296	1244	96.0
Телефон цэг	тоо	173	369	213.2



Е-майл хаяг:

Вэб хаяг:

Мэдээллийн сангийн хаяг:

Утас: 70543222, 70543017

govisumber@nso.mn

govisumber.ubseg.gov.mn

www.1212.mn